

UCS 1404B:2022

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ




Саравч, сүүдрэвчинд тавих ерөнхий шаардлага

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

Саравч, сүүдрэвчинд тавих
ерөнхий шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 23-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	6
2. Норматив эшлэл.....	6
3. Нэр томъёоны тодорхойлолт	6
4. Хүний амьдрах орчинд үүсэх нарны хэт халалтыг хязгаарлах шаардлага.....	7
5. Саравч, сүүдрэвчинд тавигдах ерөнхий шаардлага	8
6. Төрөл ангилал	11
7. САРАВЧ, СҮҮДРЭВЧ СУУРИЛУУЛАХ	12
8. САРАВЧ, СҮҮДРЭВЧИЙН МАТЕРИАЛД ТАВИХ ШААРДЛАГА	13
9. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН САРАВЧ, СҮҮДРЭВЧИЙГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....	14
Ашигласан материалын жагсаалт	15
Хавсралт.....	16-20

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нарны замын тусгал	7
Зураг 2. Сүүдрийн агаарын температурт үзүүлэх нөлөө (Жишээ зураг).....	8
Зураг 3. Хүүхдийн тоглоомын талбайн сүүдрэвч (Жишээ зураг)	9
Зураг 4. Саравчны шалны түвшин (Жишээ зураг)	9
Зураг 5. Саравч, сүүдрэвчийн хэсэглэлийн холбоос, бэхэлгээ (Жишээ зураг).....	10
Зураг 6. Саравчны хаалганы зай хэмжээ (Жишээ зураг)	10
Зураг 7. Саравчны хана (Жишээ зураг)	11
Зураг 8. Саравч, сүүдрэвчийн хогийн сав (Жишээ зураг).....	11
Зураг 9. Төмөр сүүдрэвч (Жишээ зураг)	12
Зураг 10. Модон сүүдрэвч (Жишээ зураг).....	12
Зураг 11. Шилэн сүүдрэвч (Жишээ зураг)	12
Зураг 12. Төмөр саравч (Жишээ зураг).....	12
Зураг 13. Модон саравч (Жишээ зураг)	12
Зураг 14. Шилэн саравч (Жишээ зураг)	12
Зураг 15. Саравч, сүүдрэвч суурилуулах хэсэглэл (Жишээ зураг)	12

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нэг удаа үйлчлүүлэх хүний тоо.....	9
Хүснэгт 2. Саравч, сүүдрэвч хийх материалын тохиромжтой байдлын үнэлгээ.....	13
Хүснэгт 3. Хийц эдлэлийн материал сонгох үнэлгээ.....	13
Хүснэгт 4. Хүлээн авах шалгуур үзүүлэлт.....	14



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

┌ Нийтийн эзэмшлийн эд хөрөнгөд ┐
хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:


1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

- 1.1. UCS1402B:2022 “Нийтийн эзэмшлийн талбайд байгуулах усан оргилуурт тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.2. UCS1401B:2022 “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” хотын стандарт
- 1.3. UCS1403B:2022 “Гадна мэдээллийн байгууламжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.4. UCS 1404B:2022 “Саравч, сүүдрэвчинд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.5. UCS1405B:2022 “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.6. UCS1406B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн саванд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.7. UCS1407B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн сандалд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.8. UCS1408B:2022 “Хөшөө дурсгал, хүндэтгэлийн самбарт тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.9. UCS1409B:2022 “Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.10. UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1116100320

2.Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА  Ж.БАТБАЯСГАЛАН



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 25
дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

UCS 1404B:2022 “САРАВЧ, СҮҮДРЭВЧИНД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг нийтийн эзэмшлийн гудамж талбайд саравч сүүдрэвч байгуулахад дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 30-01-03 Хот тосгоны төлөвлөлт. Барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 23-04-07 Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж;
- БНБД 23-04-07 Орон сууц, олон нийтийн барилга, сууцны хорооллын нутаг дэвсгэрт нарны гэрлийн шууд тусгалын үргэлжлэх хугацааг төслийн шатанд тодорхойлох аргачилсан заавар;
- БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм;
- MNS 6751:2019 Хүүхдийн тоглоомын талбай. Ерөнхий шаардлага.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Сүүдрэвч – гэж нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд байрлуулсан, 1 талдаа ханатай болон ханагүй, дээврээр нар бусад байгалийн үзэгдлээс хамгаалсан байгууламж (бороо, цас, салхи гэх мэт);

Саравч – гэж нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд байрлуулсан, 2 болон түүнээс дээш талдаа ханатай, дээврээр нар бусад байгалийн үзэгдлээс хамгаалсан байгууламж (бороо, цас, салхи гэх мэт);

Нарны шууд тусгал – гэж нарны туяа ямар нэгэн барилга, байшин, мод, уул зэрэг биетэд халхлагдалгүйгээр шууд тусах;

Нарны хэт ягаан туяа – гэж үзэгдэх гэрлээс богино рентген туяанаас урт долгионы урттай цахилгаан соронзон цацрал;

Гадна тохижилтын ажил – гэж барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, авто зам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, уран барилгын жижиг хэлбэр, гэрэлтүүлэг зэргийг барьж байгуулах үйл ажиллагаа;


Барилгын материал – гэж стандарт, эрүүл ахуй, экологийн шаардлагыг хангасан барилга байгууламжид хэрэглэгдэх эрдэс, түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүн, эдлэхүүн;

Барилгын эдлэхүүн – гэж барилга байгууламж ба түүний бүтээцийн элементийн үүрэг гүйцэтгэх зориулалт бүхий эдлэл;

Архитектурын хориглох хийц – гэж нийтийн эзэмшлийн зам талбайн суухад тохиромжгүй, хориглосон, аюултай газруудад байрлуулсан хориглох үүрэгтэй хийц.


4. ХҮНИЙ АМЬДРАХ ОРЧИНД ҮҮСЭХ НАРНЫ ХЭТ ХАЛАЛТЫГ ХЯЗГААРЛАХ ШААРДЛАГА

- 4.1. Хот байгуулалт, барилга байгууламжийн зураг төслийн шатанд өрөө тасалгаанд болон хорооллын нутаг дэвсгэрт нарны шууд тусгалын үргэлжлэх хугацааг тодорхойлох нь нарны эерэг ба сөрөг үйлчлэлийг хүний эрүүл мэндэд зүй зохистойгоор зохицуулах ач холбогдолтой.
- 4.2. Саравч, сүүдрэвч байгуулахдаа нарны замын тусгалыг ойлгож төлөвлөхгүй бол хэт ягаан туяанд өртөхөөс хамгаалж, тав тухыг хангаж чадахгүй бөгөөд ашиглалтын шаардлага хангахгүй.
- 4.3. Нарны тусгалын шаардлагыг хангуулах, нарны илүүдэл цацрагаас хамгаалахын аль алиныг архитектур төлөвлөлтийн аргаар зохицуулах нь хамгийн ашигтай байдаг. Эдгээр аргуудад барилгын ориентацийг зөв сонгох, лож, веранд, тагт, галерей төлөвлөх, ногоон суулгац хэрэглэх зэрэг аргууд орно /Зураг 1/.



Зураг 1. Нарны замын тусгал (Жишээ зураг)

- 4.4. Хот байгуулалт, барилгажилтын төсөл /орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, бичил хорооллын ерөнхий төлөвлөгөө, хот суурин газрын барилгажилтын төсөл/-д энэхүү нормоор шаардагдах нарны шууд тусгалын үргэлжлэх хугацааны шаардлагыг хэрхэн тооцож хангасан тухай болон ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлийн талаар тайлбар бичгийн хүрээлэн буй орчныг хамгаалах бүлэгт тусгай дэд бүлэг болгон бичиж оруулна.
- 4.5. Нарны тусгалын үргэлжлэх норматив хугацааг дараах талбайд заавал хангуулна. Үүнд:
- 4.6.1. орон сууцны хорооллын хүүхэд тоглох болон биеийн тамирын талбай;
- 4.6.2. сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын тоглоомын болон биеийн тамирын талбай;
- 4.6.3. ерөнхий боловсролын болон дотуур байртай сургуулийн биеийн тамир, амралт, сургалт, туршлагын талбай.
- 4.6. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалахын тулд шууд ба шууд бус хэт ягаан туяанаас хамгаалах гадна орчныг бий болгох шаардлагатай /Зураг 2/.



Зураг 2. Сүүдрийн агаарын температурт үзүүлэх нөлөө (Жишээ зураг)

- 4.7. Хорооллын талбайг нарнаас хамгаалахдаа барилгаар сүүдэрлэх, орчныг тохижуулж, тусгай сүүдрэвч хийх буюу мод тарих аргаар шийдвэрлэнэ.

5. САРАВЧ, СҮҮДРЭВЧИНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 5.1. Саравч, сүүдрэвч нь хотын өнгө үзэмжид барилга архитектурын шийдлийг тодорхойлох хэрэгсэл төдийгүй, иргэдийн ая тухтай амарч, зугаалах боломжийг бүрдүүлдэг чухал байгууламж юм.
- 5.2. Нийтийн эзэмшлийн талбайг тохижуулахдаа саравч, сүүдрэвчийг орчны архитектурын төлөвлөлттэй уялдуулан хийнэ.
- 5.3. Хотын хүн амын суурьшлын бүсээс хамааруулан цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж бүхий газрын 1 удаад үйлчлэх хүний тоо хэмжээг тооцон гаргадаг. Ногоон бүс, ой, ойн бүс, цэцэрлэгт хүрээлэнд нэгэн зэрэг үйлчлүүлэх хүний тоог доор зааснаас ихгүйгээр тооцож төлөвлөнө.
- 5.4. Нэг удаа үйлчлүүлэх хүний тооноос хамааран саравч, сүүдрэвч, сандлыг хангалттай хэмжээгээр тооцож байрлуулах бөгөөд хүн/га-д оногдох хэмжээг Хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1. Нэг удаа үйлчлүүлэх хүний тоо

Төрөл	Тоо хэмжээ (хүн/га)
Хотын цэцэрлэгт хүрээлэнд	100
Амралт, зугаалгын орчны цэцэрлэг, ногоон бүсэд	70
70 Амралт сувиллын тосгоны ногоон бүсэд	50
Ойн төгөл, нуган төгөл, усан хүрээлэн	10

5.5. Нийтийн эзэмшлийн талбайд саравч сүүдрэвчийг төлөвлөхдөө явган зорчигчийн аюулгүй байдал, саадгүй зорчих нөхцөлийг хангах ба “Явган хүний зам, талбайн төлөвлөлт хучилт, угсралтад тавих шаардлага” UCS 0901B:2022 баримт бичгийн шаардлагыг хангасан байна.

5.6. Хүүхэд элсээр тоглох талбай байгуулсан бол тодорхой хэсэгт нь заавал сүүдрэвч байгуулна (Зураг 3).



Зураг 3. Хүүхдийн тоглоомын талбайн сүүдрэвч (Жишээ зураг)

5.7. Иргэд олноор цуглардаг газруудад нар салхинаас хамгаалах зорилгоор саравч, сүүдрэвчийг хүн амын төвлөрлийн тоо хэмжээтэй уялдуулан байгуулах шаардлагатай.


5.8. Нийтийн тээврийн автобусны зогсоолын саравч нь UCS 1601B:2022 стандартын шаардлагыг хангасан байна.

5.9. Нийтийн эзэмшлийн зам талбайд байрлуулах саравч, сүүдрэвчид орж гарахад зориулсан шалыг явган зам, талбайтай нэг түвшинд, хаалгыг босгогүй хийнэ (Зураг 4).



Зураг 4. Саравчны шалны түвшин (Жишээ зураг)

5.10. Саравч, сүүдрэвчийн бүрдэл хэсгийг холбож угсрахад хялбар байх шаардлагатай бөгөөд эвдэрсэн тохиолдолд солих буюу засварлахад энгийн байвал зохино (Зураг 5). Жишээ нь: Углуурга, оньс зэрэг холбоос бэхэлгээг сольж угсрахад хялбар байх шийдлийг сонгон хэрэглэнэ.



Зураг 5. Саравч, сүүдрэвчийн хэсэглэлийн холбоос, бэхэлгээ (Жишээ зураг)

5.11. Саравчинд орох гарах хаалга, тэргэнцэртэй иргэнд зориулсан талбайн өргөн 0.9 м, урт нь 1.5 м-ээс багагүй байна. Нэвтрэх хаалганы өндөр 2.1 м-ээс багагүй байна. Саравчны хаалганы зай хэмжээг Зураг 6-д үзүүлэв.



Зураг 6. Саравчны хаалганы зай хэмжээ (Жишээ зураг)

- 5.12. Саравч, сүүдрэвчинд нөлөөлөх салхины хурд, салхины ба цасны ачааллыг тооцож бат бөх хийнэ.
- 5.13. Саравчны ханыг салхи чөлөөтэй нэвтрүүлэх боломжтой байдлаар төлөвлөх нь тохиромжтой (Зураг 7).



Зураг 7. Саравчны хана (Жишээ зураг)

- 5.14. Саравч, сүүдрэвчийн дотор талд хогийн сав байрлуулах нь тохиромжгүй бөгөөд хөдөлгөөний эрчим төвлөрч байгаа газруудад хог хаягдлыг ангилан хаях боломжтой байна.
- 5.15. Хогийн савыг байрлуулахад UCS1407B:2022 стандартын шаардлагыг хангасан байна.




Зураг 8. Саравч, сүүдрэвчийн хогийн сав (Жишээ зураг)

6. ТӨРӨЛ АНГИЛАЛ

- 6.1. Нийтийн эзэмшлийн саравч, сүүдрэвчийн хийсэн материалаас нь хамааруулж модон, төмөр, шилэн /хатжуулсан/ гэж ангилна (Зураг 9).
- 6.2. Саравч, сүүдрэвчийг дээрх материалуудыг хослуулан архитектур, ландшафтын шийдлээр өнгө үзэмтэй, бат бөх, чанартай, хүртээмжтэй байхаар төлөвлөж хийнэ.

Сүүдрэвчийн төрөл:



Зураг 9. Төмөр сүүдрэвч
(Жишээ зураг)



Зураг 10. Модон сүүдрэвч
(Жишээ зураг)



Зураг 11. Шилэн сүүдрэвч
(Жишээ зураг)



Зураг 12. Төмөр саравч
(Жишээ зураг)




Зураг 13. Модон саравч
(Жишээ зураг)



Зураг 14. Шилэн саравч
(Жишээ зураг)

7. САРАВЧ, СҮҮДРЭВЧ СУУРИЛУУЛАХ

- 7.1. Саравч, сүүдрэвчийг суурилуулахдаа орчны аюулгүй байдлыг хангах зорилгыг урьтал болгоно.
- 7.2. Саравч, сүүдрэвчийг газарт хөдөлгөөнгүй суурилуулах бөгөөд суурийн бетон эдлэлд зөвхөн тэлэгч боолт ашиглаж газрын гадаргад бэхэлнэ.
- 7.3. Саравч, сүүдрэвчийн үндсэн хийц эдлэхүүний нийт жингээс хамааруулан суурийн бетон эдлэлийн хэмжээг тооцно.
- 7.4. Саравч, сүүдрэвчийг суурилуулах суурийн хэсэглэлийг Зураг 10-т үзүүлэв.



Зураг 15. Саравч, сүүдрэвч суурилуулах хэсэглэл (Жишээ зураг)

8. САРАВЧ, СҮҮДРЭВЧИЙН МАТЕРИАЛД ТАВИХ ШААРДЛАГА

- 8.1. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, зураг төслийн шаардлагыг бүрэн хангасан барилгын материалаар хийгдсэн байна.
- 8.2. Саравч, сүүдрэвчийн модон хийцийн эдэлгээг уртасгах зорилгоор ус чийг тусгаарлах зориулалт бүхий стандарт шаардлага хангасан будгаар технологийн дагуу будсан байна.
- 8.3. Саравч, сүүдрэвчийн металл хийц хэсгүүдийг зэвэрдэггүй материалаар хийх, эсхүл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэгийг стандарт шаардлага хангасан будгаар технологийн дагуу будсан байна.
- 8.4. Саравч, сүүдрэвчийн эдлэхүүнийг шилээр хийх тохиолдолд ганшуулсан шил, поликарбонат материал ашиглах шаардлагатай.
- 8.5. Монгол орны цаг уурын эрс тэрс нөхцөл байдалд нийтийн эзэмшлийн зам талбай цэцэрлэгт хүрээлэнд байрлуулах саравч, сүүдрэвч, түүний суудлыг модон материалаар хийнэ.
- 8.6. Доор хүснэгтэд саравч, сүүдрэвч хийх материалын тохиромжтой байдлын үнэлгээг Хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. Саравч, сүүдрэвч хийх материалын тохиромжтой байдлын үнэлгээ

Үзүүлэлт	Үндсэн материалын төрөл			
	Мод	Шил	Хуванцар	Металл
Тухтай байдал				
Температурын өөрчлөлтөд дулаан, хүйтнийг дамжуулахгүй байх шинж чанар				
Будах шаардлагатай				
Цэвэрлэгээний шаардлага				
Хүйтэн цаг уурт хайрахгүй, жиндүүлэхгүй байх шинж чанар				

Тохиромжтой
 Тохиромж багатай
 Тохиромжгүй

- 8.7. Саравч, сүүдрэвчийг байрлуулах талбайгаас хамааруулан хийц эдлэхүүний материалыг сонгох нь тохиромжтой. Тохиромжтой байдлын үнэлгээг Хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 3. Хийц эдлэлийн материал сонгох үнэлгээ

Үзүүлэлт	Үндсэн материалын төрөл			
	Мод	Шил	Хуванцар	Металл
Нийтийн эзэмшлийн зам талбайд				
Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжид				
Амралт, зугаалгын орчны цэцэрлэгт				
Ойн төгөл, нуган төгөл, усан хүрээлэн				
Автобусны зогсоол				

Тохиромжтой
 Тохиромж багатай
 Тохиромжгүй

9. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН САРАВЧ, СҮҮДРЭВЧИЙГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Саравч, сүүдрэвчид тавигдаж байгаа материал, үйлдвэрлэлийн шаардлага, хэмжээ, загвар, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг хүлээн авах шалгуур үзүүлэлтийг Хүснэгт 4 -ийн дагуу хянан шалгаж хүлээн авна.


Хүснэгт 4. Хүлээн авах шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Саравч, сүүдрэвчийг зөв байрлалд, зөв харуулж байршуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Саравч, сүүдрэвчийн бүтээц, эдлэхүүн стандартын шаардлага хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Саравч, сүүдрэвч нь нийтийн эзэмшлийн саравч, сүүдрэвчийн зай хэмжээний стандартад нийцэж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Саравч, сүүдрэвчийн модон хийц хэсгүүдэд байгалийн болон механик нөлөөллөөс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Саравч, сүүдрэвчийн металл хийц хэсгүүд зэвэрдэггүй материалаар хийгдсэн аль эсхүл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Саравч, сүүдрэвчийг стандартын дагуу суурилуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Саравч, сүүдрэвчийн шал явган зам, талбайтай нэг түвшинд байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Саравч, сүүдрэвчийн сандал нь стандартын шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>


Тайлбар: Хотын нийтийн эзэмшлийн саравч, сүүдрэвч нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Хот байгуулалтын тухай хууль
- Барилгын тухай хууль
- БНБД 23-04-07 Орон сууц, олон нийтийн барилга, сууцны хорооллын нутаг дэвсгэрт нарны гэрлийн шууд тусгалын үргэлжлэх хугацааг төслийн шатанд тодорхойлох аргачилсан заавар
- БНБД 23-04-07 Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж
- БНБД 30-01-03 Хот тосгоны төлөвлөлт. Барилгажилтын норм ба дүрэм
- БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм
- MNS 6751:2019 Хүүхдийн тоглоомын талбай. Ерөнхий шаардлага
- UCS 0001-01:2019 Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага
- UCS 1403C:2020 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулсан хогийн саванд тавих шаардлага
- UCS 1404C:2020 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулсан сандалд тавих шаардлага
- UCS 1601B:2020 Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих шаардлага



ХАВСРАЛТ 2. (Жишээ зураг)



ХАВСРАЛТ 3. (Жишээ зураг)

САРАВЧ, СҮҮДРЭВЧ

СУУРИЙН ХЭСЭГЛЭЛ /M1:20/

ДЭЭВРИЙН ХЭСЭГЛЭЛ

ХЭСЭГЛЭЛ

ДЭЭВРИЙН ДАМНУРУУНЫ ХЭСЭГЛЭЛ /M1:10/

САРАВЧ, СҮҮДРЭВЧ

Архитектор	О.Билэгүүн	ХЭСЭГЛЭЛ	
Гүйцэтгэсэн	О.Билэгүүн	Х.С.-Дугаар:	Масштаб:
Шалгасан	Б.Од-Эрдэнэ	USC-14.02C	M1:20
		Зургийн дугаар:	Хуудас:
		04	08
		Огноо:	Хянасан огноо:
		2020	2020

ХАВСРАЛТ 4. (Жишээ зураг)

САРАВЧ, СҮҮДРЭВЧ

ХАРАГДАХ БАЙДАЛ




Тайлбар

– Хотын өнгө үзэмжийг тодорхойлохоос гадна саравч, сүүдрэвч нь нар салхинаас хамгаалах чухал хэрэгсэл тул нарны тусгаалаас хамгаалах болон салхины чиглэлийг тооцоолж төлөвлөх шаардлагатай.

– Нийтийн хэрэгцээний нутаг дэвсгэрийг усан оргилуур, усан сан, шат, налуу зам, саравч, сүүдрэвч, гэрэлтүүлэг зэрэг архитектурын жижиг хэлбэрээр тоноглож тохижуулан төлөвлөнө (БНБД 30.0103-4.9).


МАТЕРИАЛЫН ТҮҮВЭР	
Материалын нэр	Хөндлөн огтлол
1	
2	
3	
4	
5	
6	
7	

САРАВЧ, СҮҮДРЭВЧ		ХАРАГДАХ БАЙДАЛ	
	Архитектор	Х.С.-Дугаар: USC-14.02С	Огноо: 2020
	Гүйцэтгэсэн	Х.С.-Дугаар: USC-14.02С	Масштаб: М1:20
	Шалгасан	Зургийн дугаар: 05	Хуудас: 08
	О.Билгүүн		Хянасан огноо: 2020
	О.Билгүүн		
	Б.Ов-Эрдэнэ		

ХАВСРАЛТ 5. (Жишээ зураг)


САРАВЧ, СҮҮДРЭВЧ

ХАРАГДАХ БАЙДАЛ




БОЛОМЖИТ ХУВИЛБАРУУД


НҮҮР ТАЛ М1:200




ХАЖУУ ТАЛ М1:200



ДЭЭВРИЙН БАЙГУУЛАЛТ М1:200



САРАВЧ, СҮҮДРЭВЧ		БОЛОМЖИТ ХУВИЛБАРУУД	
Архитектор	О.Билгүүн	Х.С.-Дугаар:	УС-14.02С
Гүйцэтгэсэн	О.Билгүүн	Масштаб:	М1:200
Шалгасан	Б.Од-Эрдэнэ	Зургийн дугаар:	Худвас: 08
		Огноо:	2020
		Хянасан огноо:	2020





Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар